МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 23 өдөр Дугаар А/58 Улаанбаатар хот

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17 дахь заалт, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, БНСУ-ын "Рафаэл клиник интернэйшнл" ТББ хоорондын эрүүл мэндийн сайн дурын үйл ажиллагааны хамтын ажиллагааны гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох гадаадын 2 эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтын дагуу зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Д.Оюунчимэг/-д даалгасугай.

САЙД А.ЦОГЦЭЦЭГ

080227

Эрүүл мэндийн сайдын
2016 оны 09 сарын 23 өдрийн
А/358 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

| № | Овог нэр | Харьяалал | Ажиллах байгууллага | Гэрчилгээний сери/дугаар | Төрөлжсөн мэргэшлийн чиглэл | Зөвшөөрлийн төрөл | Хүчинтэй хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Жон Чан Уг<br>Jeong Chang Wook | БНСУ | Улсын нэгдүгээр төв эмнэлэг | ГЭ0001655 | Бөөрний мэс засал | Эмчлэх | 2016-09-29<br>2016-10-01<br>4 хоног |
| 2. | Мин Сан Ил<br>Min Sangil | БНСУ | Улсын нэгдүгээр төв эмнэлэг | ГЭ0001656 | Ерөнхий мэс засал | Эмчлэх | 2016-09-29<br>2016-10-01<br>4 хоног |